



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Худалдан авах ажиллагааны газрын  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** БУА-2026/47/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Булган аймаг  
2026 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Д.Батцогт  
Утас: 7034-2580 Цахим хаяг: [Battsogtd@audit.gov.mn](mailto:Battsogtd@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Анхбаяр  
Цахим хаяг: [Ankhubayard@audit.gov.mn](mailto:Ankhubayard@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Нэг. Аудитын санал дүгнэлт



### БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 132

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА  
Б.БАЯРЦЭНГЭЛ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Цахим платформ системүүдийн уялдаа холбоог ханган худалдан авах ажиллагааг хурдан шуурхай, хялбар, ил тод, нээлттэй зохион байгуулсан байна.

Аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 85 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

### Аудитын гол асуудал

2025 оны байдлаар Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/765 тоот захирамжаар "Аймгийн Худалдан авах ажиллагааны газар байгуулж, дүрэм, бүтэц орон тоо"-г 10 албан хаагчтай байхаар батлагдаж, аймгийн 2025 оны төсөвт 6 орон тоогоор батлагдан тайлангийн жилд 5 албан хаагч ажиллаж байна.

### Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

## Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,920,890.00</u></b>	<b><u>6,969,314.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	4,920,890.00	6,969,314.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	4,920,890.00	6,969,314.00
35410	Бичиг хэргийн материал	260,000.00	435,000.00
35420	Аж ахуйн материал	3,930,890.00	6,534,314.00
35440	Түлш, шатах тослох материал	730,000.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>28,329,579.22</u></b>	<b><u>48,223,088.28</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	28,329,579.22	48,223,088.28
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	25,106,662.56	45,912,671.66
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,172,240.00	2,172,240.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,086,120.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20,566,375.66	39,954,772.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,858,265.88)	(13,925,830.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,965,752.00	22,628,141.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,739,439.22)	(3,830,530.85)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	3,222,916.66	2,310,416.62
39301	Програм хангамж	3,650,000.00	3,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(427,083.34)	(1,339,583.38)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>33,250,469.22</u></b>	<b><u>55,192,402.28</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>160,000.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	160,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	160,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	160,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	160,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>33,250,469.22</u></b>	<b><u>55,032,402.28</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	33,250,469.22	55,032,402.28
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	33,250,469.22	55,032,402.28
51210	Өмнөх үеийн үр дүн	33,250,469.22	33,250,469.22
51220	Тайлант үеийн үр дүн	-	21,781,933.06
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>33,250,469.22</u></b>	<b><u>55,192,402.28</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	-	<b>292,067,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>11,900,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	11,900,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	11,900,000.00

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	11,900,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	-	<b>280,167,300.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	280,167,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	280,167,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>269,858,072.79</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>269,858,072.79</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	264,479,435.51
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	209,505,454.72
210101	Үндсэн цалин	-	113,640,695.00
210102	Нэмэгдэл	-	70,409,758.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	8,928,000.00
210104	Урамшуулал	-	16,527,001.72
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	26,188,183.00
210201	Тэтгэврийн даатгал	-	17,807,964.60
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,095,055.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,047,525.80
210204	Ажилгүйдлийн даатгал	-	1,047,525.80
210205	Эрүүл мэндийн даатгал	-	4,190,111.20
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	7,131,900.00
210401	Бичиг хэрэг	-	3,451,500.00
210402	Тээвэр, шатахуун	-	2,530,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	718,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	432,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	5,403,200.00
210702	Дотоод албан томилолт	-	5,403,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	58,180.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	36,180.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	16,192,517.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,917,422.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,224,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	12,050,595.79
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	5,378,637.28
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	750,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	4,628,637.28
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,628,637.28
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	-	<b>22,209,227.21</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	427,294.15
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	427,294.15
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(427,294.15)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	=	<b>21,781,933.06</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	-	<b>292,067,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>11,900,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	11,900,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	11,900,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	11,900,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	-	<b>280,167,300.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	280,167,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	280,167,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	-	<b>259,695,901.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>259,695,901.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>254,317,263.72</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	209,505,454.72
210101	Үндсэн цалин	-	113,640,695.00
210102	Нэмэгдэл	-	70,409,758.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	8,928,000.00
210104	Урамшуулал	-	16,527,001.72
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	26,188,183.00
210201	Тэтгэврийн даатгал	-	17,807,964.60
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,095,055.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,047,525.80
210204	Ажилгүйдлийн даатгал	-	1,047,525.80
210205	Эрүүл мэндийн даатгал	-	4,190,111.20
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	7,131,324.00
210401	Бичиг хэрэг	-	3,627,924.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	718,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	985,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	1,714,000.00
210602	Тавилга	-	1,714,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	5,403,200.00
210702	Дотоод албан томилолт	-	5,403,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	58,180.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	36,180.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	4,316,922.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,917,422.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,399,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>5,378,637.28</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	750,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	4,628,637.28
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,628,637.28
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-</b>	<b>32,371,399.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>32,371,399.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>32,371,399.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	32,371,399.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	32,371,399.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-</b>	<b>(32,371,399.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	33,250,469.22	33,250,469.22
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	21,781,933.06	21,781,933.06
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	55,032,402.28	55,032,402.28

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

	Үзүүлэлт	Тайлант оны
--	----------	-------------

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	289,597,600.00	285,433,662.72	4,163,937.28	98.56
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	289,597,600.00	285,433,662.72	4,163,937.28	98.56
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	288,847,500.00	284,833,662.72	4,013,837.28	98.61
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	211,140,300.00	209,505,454.72	1,634,845.28	99.23
210101	Үндсэн цалин	88,010,000.00	113,640,695.00	(25,630,695.00)	129.12
210102	Нэмэгдэл	94,630,300.00	70,409,758.00	24,220,542.00	74.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,000,000.00	8,928,000.00	3,072,000.00	74.40
210104	Урамшуулал	16,500,000.00	16,527,001.72	(27,001.72)	100.16
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,392,500.00	26,188,183.00	204,317.00	99.23
210201	Тэтгэврийн даатгал	17,946,900.00	17,807,964.60	138,935.40	99.23
210202	Тэтгэмжийн даатгал	2,111,400.00	2,095,055.60	16,344.40	99.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,055,700.00	1,047,525.80	8,174.20	99.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,055,700.00	1,047,525.80	8,174.20	99.23
210205	Эрүүл мэндийн даатгал	4,222,800.00	4,190,111.20	32,688.80	99.23
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,305,300.00	6,646,324.00	658,976.00	90.98
210401	Бичиг хэрэг	3,788,000.00	3,627,924.00	160,076.00	95.77
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,800,000.00	-	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	732,300.00	718,400.00	13,900.00	98.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	985,000.00	500,000.00	485,000.00	50.76
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	34,085,600.00	34,085,399.00	201.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,899,500.00	19,899,400.00	100.00	100.00
210602	Тавилга	14,186,100.00	14,185,999.00	101.00	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,403,300.00	4,033,200.00	1,370,100.00	74.64
210702	Дотоод албан томилолт	5,403,300.00	4,033,200.00	1,370,100.00	74.64
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	58,400.00	58,180.00	220.00	99.62
210803	Даатгалын үйлчилгээ	100.00	-	100.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	36,300.00	36,180.00	120.00	99.67
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	-	100
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,462,100.00	4,316,922.00	145,178.00	96.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,062,500.00	1,917,422.00	145,078.00	92.97
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,399,600.00	2,399,500.00	100.00	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	750,100.00	600,000.00	150,100.00	79.99
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	750,100.00	600,000.00	150,100.00	79.99

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	250,100.00	100,000.00	150,100.00	39.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	-	100
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	289,902,300.00	(289,902,300.00)	
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	280,167,300.00	(280,167,300.00)	
132001	Орон нутгийн төсвөөс	-	280,167,300.00	(280,167,300.00)	
<b>1E+05</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	9,735,000.00	(9,735,000.00)	
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,735,000.00	(9,735,000.00)	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	2.00	2.00	0.00	100
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00	0.00	100
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	5.50	5.50	0.00	100
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	0.00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	3.00	3.00	0.00	100
620003	Үйлчлэх ажилтан	0.50	0.50	0.00	100

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,005,000.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,005,000.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,855,000.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	485,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	485,000.00
<b>Томилолт, зочны зардал</b>	1,370,000.00
Дотоод албан томилолт	1,370,000.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	150,000.00
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	150,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	150,000.00

## **Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Аймгийн Худалдан авах ажиллагааны газар /цаашид ХААГ/ нь “Газрын эрхэм зорилго нь худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн хууль журмын дагуу зохион байгуулж, төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулахад оршино” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулжээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Хууль тогтоомжоос салбар, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, байгууллагын үйл ажиллагаанд хамаарах чиг үүргийг тодорхойлох;
2. Тухайн чиг үүргүүдийг үйл ажиллагааны чиглэлээр ангилах;
3. Салбар хоорондын болон засаглалын түвшин хоорондын холбогдогч талуудын оролцоог тодорхойлох;
4. Чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох;

### **Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон бусад хууль, тогтоомжууд, эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажилласан байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ХААГ нь Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар баталсан НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

## **Дөрөв. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Монгол Улсын Шатар сайдтай аймгийн Засаг дарга 2025 онд хамтран ажиллах гэрээний дагуу тус аймагт гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилт зохион байгуулан ажилласан байна.

Аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилт, 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

### **Тав. Аудитын гол асуудал**

2025 оны Онцгой байдлын газрын даргын А/01 тушаалаар 2025 онд батлагдсан орон тоо 152, гүйцэтгэлээр 132 албан хаагч ажиллаж байна 20 албан хаагчдын орон тоо дутуу ажиллаж байна. Гал сөнөөгч 6, техник хариуцсан мэргэжилтэн 1, сэтгэл зүйч 1, цэргийн хэргийн мэргэжилтэн 1, гамшгаас хамгаалах байцаагч 1, аврагч 5, агарномч 2, жолооч 3 зэрэг орон тоо дутуу ажилласан байна.

### **Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

#### **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг хэрэгжүүлээгүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

#### **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн аудитаар санхүүгийн тайлангийн тодруулгыг журамд нийцүүлсэн бэлтгэсэн эсэхийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **Найм. Аудитын илрүүлэлт**

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй.